



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*Гүйцэтгэлийн аудитын тайлан*

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил зохих үр өгөөжөө өгч байна.**



Өлгий

## АГУУЛГА

<b>Тайланг бэлтгэсэн:</b>	Товчилсон үгийн тайлбар	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
<b>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</b>	<b>Бүлэг 1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөжээ.</b>	7-10
		9-10
<b>Дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган</b>	<b>Бүлэг 2 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна</b>	11-12
<b>Аудитын менежер Х.Женисбек</b>	<b>Бүлэг 3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил зохих үр өгөөжөө өгч байна.</b>	13-14
<b>Ахлах аудитор К.Риза</b>	<b>Дүгнэлт.....</b>	15
	<b>Зөвлөмж:</b>	16
<b>Аудитор Р.Баярмаа</b>	<b>Холбогдох байгууллагын санал:</b>	17
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал .....	
	<b>Саналд өгсөн тайлбар .....</b>	
<b>2018 оны 4 дүгээр сар</b>		
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94156768, 99265539 дугаарын утсаар харилцана уу		
<b>ХАЯГ:</b>		
Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 105, 106, 108 тоот өрөө		



## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### Аудитын зорилт

Тус аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө, Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгах, цаашид засаж сайжруулах санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

### Хамарсан хүрээ

Энэхүү аудитад аймаг, сумдын ИТХурал, Засаг дарга, ЗДТГазраас Орон нутгийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй холбогдож гаргасан эрхийн акт, шийдвэр, Худалдан авах ажиллагааны нэгжээс зохион байгуулсан ажлын үр дүн, ажлын явцын болон холбогдох санхүүгийн ажлын тайлан, бусад тооцоо судалгаа үйл ажиллагаануудыг хамрууллаа.

### Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, харилцан ярилцлагад тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журам, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, ОНӨГазрын худалдан авах ажиллагааны холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, санал, асуулга, лавлагаа авах, фото, судалгаа авч дүн, шинжилгээ хийх, зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### Үндсэн мэдээлэл:

Тус аймагт Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр 4513,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг 1752,3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Аймгийн ИТХ-аас Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд 300,4 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

## Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

1. Төрийн аудитын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
6. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
7. Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
8. Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах аудитор К.Риза ахалж, аудитор Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 19-ныг хүртлэх хугацаанд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудит хийж аудитын тайланг бэлтгэв. Аудитын тайлангийн хавсралт судалгаа мэдээнүүдийг тайланд хавсаргасан болно.

## Бүлэг 1

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн хөтөлбөр, бодлогод нийцүүлэн төлөвлөсөн байна.**

### Оршил

Аймгийн ИТХ-ын 2017 оны ээлжит IV хуралдааны 16 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар 2016 оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 628,1 сая төгрөгнөөс 216,9 сая төгрөгийг хөрөнгө олж бэлтгэхтэй холбогдсон зардал, урьд хэрэгжсэн 11 төсөл арга арга хэмжээний дутуу санхүүжилт буюу шилжих хөрөнгө оруулалтанд, 180.2 сая төгрөгийг 2017 онд шинээр хэрэгжих орон нутгийн хөрөнгө оруулалтын 18 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус баталсан байна.

Мөн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 4 удаагийн тогтоолоор Замын санд төлөвлөгдсөн хөрөнгөнөөс 180,2 сая төгрөгийг авто замын чиглэлээр хэрэгжих төсөл арга хэмжээнд зарцуулахаар баталжээ.

**А.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөжээ.**

**А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн хөтөлбөр, бодлогод нийцүүлэн төлөвлөсөн байна.**

Баян-Өлгий аймагт 2017 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, салбарын бодлоготой уялдсан байна.

2017 онд аймгийн хэмжээнд шаардлагатай Хөрөнгө оруулалтын ажлын төслийг салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтсээс нэгтгэн, шаардлагатай тооцоо судалгааны хамт аймгийн Засаг даргаар хянуулан батлуулжээ. Орон нутгийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээнүүд нь дээрхи хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон эрэмбэлсэн жагсаалтанд орсон ажлууд байна.

**А.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд холбогдох хууль журмуудыг зөрчсөн зөрчлүүд байна.**

2017 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой ба ашиглагч байгууллага нь тодорхойгүй төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй бөгөөд хэрэгжих явцад төсөл арга хэмжээний нэр, хугацаа, байршилд өөрчлөлт ороогүй байна.

2017 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж шинээр хэрэгжихээр батлагдсан Өлгий сумын 13 дугаар багийн 18 айлын

цахилгааны шугам татах ажил болон Замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Өлгий сумын 8 дугаар багийн гэрлэн дохио, Улаанхус сумын Согоог багийн гүүрийн 2 талын засварын ажил, Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын нөхөөсний ажил, Алтанцөгц сумын Цагаан гатлахын гүүрийн засвар зэрэг 105,5 сая төгрөгийн өртөг бүхий 5 төсөл арга хэмжээний зураг төсөв нь төсөв батлагдсаны дараа хийгдэж, төсвийн төсөл боловсруулах журмыг зөрчжээ.

Иймд Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1-хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3-д “Хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэснийг үндэслэн дээрхи зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Аймгийн ЗДТГазар, МХГазарт автомашин нийлүүлэх”, “Аймгийн Нэгдсэн эмнэлэг, ”Сансар” эмнэлэг, “Раушан өрхийн эмнэлэгт эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга нийлүүлэх”, “Аймгийн Нэгдсэн эмнэлэгт программ хангамж, камер суурилуулах ажил хийх”, “Аймгийн ЗДТГазарт тавилга нийлүүлэх” зэрэг төсөл арга хэмжээнүүдэд захиалагчаас техникийн тодорхойлолт гаргуулсан байна.

Тайлант онд зураг төсвийн дагуу ажил гүйцэтгэх явцад зураг төсөвтэй холбоотой зөрчил маргаан гараагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд шинээр хэрэгжих 180,2 сая төгрөгийн өртөг бүхий 18 төсөл арга хэмжээг төлөвлөсөний 55.0 сая төгрөгийн өртөг бүхий 10 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын чанартай биш урсгал засварын шинжтэй төсөл арга хэмжээнүүдэд төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д заасан хөрөнгө оруулалтын шалгуурыг хангахгүй байна. Цаашид Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээг тусад нь, хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинжтэй ажлуудыг тусад нь ялгаж төлөвлөж, баталж байхыг зөвлөмж болгов.

### ***А.3. ХО-ын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл хангагджээ.***

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, худалдан авах тоног төхөөрөмжийн актанд захиалагчийг төлөөлж гарын үсэг зурах эрх бүхий барилгын хяналтын болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудыг томилж, томилсон тухай шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ТЕЗ-дээс эрх шилжүүлсэн шийдвэрийг үндэслэн Орон нутгийн өмчийн газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 5 дугаар сараас 10 дугаар сарын хооронд явуулахаар баталсан байна.

## Бүлэг 2

*Орон нутгийн 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын  
төсөл, арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн байна.*

**Б. 2017 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.**

***Б.1.3. Цахим сайтад байршуулсан зарим мэдээлэлүүд зөрүүтэй, үнэлгээний хорооны тайлангийн бичиг баримтын бүрдүүлэлт бүрэн хангагдаагүй байна.***

Захиалагчаас боловсруулж, эрх бүхий зураг төсөвчнээр хийлгэсэн ажлын даалгавар, зохих стандарт шаардлага норм нормативт үндэслэн зориулалтыг бүрэн заасан техникийн тодорхойлолтыг боловсруулан гаргасан байна.

Үнэлгээний хороог Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь зүйлд заасан шаардлагыг хангахуйц худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, АЗ сертификаттай, худалдан авах ажиллагааны салбарын мэргэжилтнүүд болон аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын төлөөллийг оролцуулан 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилласан байна.

Захиалагчаас тендерийн бичиг баримтыг тендерийн урилга тараахаас өмнө боловсруулан тендерт оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдэд урилгын хамт тараасан байна.

Орон нутгийн өмчийн газрын 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу бараа ажил үйлчилгээний өртөг нь шууд худалдан авч болох босго үнээс давсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн босго үнээс бага төсөвт өртөгтэй 36,1 сая төгрөгийн өртөг бүхий 6 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн аймгийн ЗДТГ-т автомашин худалдан авах, Улаанхус сумын Согоог багийн гүүрийн 2 талын засвар, Аймгийн ЗДТГазарт тавилга нийлүүлэх, 8 дугаар багийн замын уулзварт гэрлэн дохио байрлуулах, Алтанцөгц сумын Цагаан гатлангийн гүүрийн засварын ажил, ЗДТГазарт тавилга худалдан авах төсөл арга хэмжээнүүдийн баримтанд үнэлгээний хорооны гишүүд “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн маягтуудыг хууль журмын дагуу бүрэн гүйцэд хөтөлж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.



Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2017 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний товч тодорхойлолт, тендерийн бичиг баримт, тендер оролцогчдын ирүүлсэн тендер зэргийг цахим болон цаасан хэлбэрээр төсөл арга хэмжээ бүрээр архивын нэгж болгон хадгалсан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газраас тогтоосон босго үнийг баримтлан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар журмын дагуу зохион байгуулж явуулжээ.

2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газрын ХААУХШМ-ийн системд оруулан Өглөөний сонинд нийтэлж, аймгийн “Tender.gov.mn”, “Tender.bo.gov.mn”, “bayan-ulgii.gov.mn”, “e-procurement.mn”, “meps.gov.mn” сайтуудаар нийтэд зарлан мэдээлж, гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.

Орон нутгийн өмчийн газар нь 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээг цахим хэлбэрээр, 2 төсөл арга хэмжээг уламжлалт аргаар зохион байгуулсан байна.

Үнэлгээний хорооноос тендер шалгаруулах явцад хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь заалтыг зөрчсөн дараахь зөрчлүүдийг гаргажээ. Үүнд:

-Өлгий сумын 8 дугаар багийн замын уулзварт гэрлэн дохио байрлуулах ажил ТАХ-г харьцуулалтын аргаар цахим хэлбэрээр худалдан авалт зарласан боловч компаниудаас тендерийн бичиг баримт ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн байна. Үнэлгээний хорооны дүгнэлтэд тендерийг 2017 оны 06 дугаар 23-ны өдөр “Tender.gov.mn”, “Tender.bo.gov.mn” сайтуудад зарласан гэж тайлагнасан боловч “Tender.bo.gov.mn” сайтад 06 дугаар сарын 27-ны өдөр зарласан гэж хадгалагдсан ба тендерийг 06 дугаар сарын 29-ний өдөр нээсэн байна.

-Улаанхус сумын Согоог багийн гүүрийн 2 талын засварын ажлын тендерийн бичиг баримтанд 6 дугаар сарын 15-ны өдөр tender.gov.mn, tender.bo.gov.mn сайтуудад байршуулсан гэж тайлагнасан боловч худалдан авалтын урилгыг tender.bo.gov.mn цахим хуудсанд 6 дугаар сарын 22-ны өдөр байршуулж, зарласан өдөр буюу 6 дугаар сарын 22-нд нээлтийг хийсэн байна.

Дээрхи цахим мэдээллийн санд тавьсан мэдээллүүд нь хуулийн хугацааг зөрчиж байгаа нь мэдээллийн сайтад өөрчлөн сайжруулалт хийх явцад хугацаа өөрчлөгдсөн байх магадлалтай, сайтад тендерийн урилга тавьсанаас хойш худалдан авах ажиллагааны арга тус бүрээр заасан хуулийн хугацаанаас өмнө сайтад хандах боломжгүй гэсэн тайлбарыг Орон нутгийн өмчийн газраас өгч байна.

Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг улирал бүр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг мэдээлэх, тайлагнах журмын 1, 2 дугаар хүснэгт маягтын дагуу гаргаж аймгийн

Засаг даргаар батлуулан, улирал бүр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

## **Б.2. Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг үндэслэлтэй боловсруулсан байна.**

2017 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт 13 засварын ажилд мэргэшсэн, тэргүүлэх зэрэгтэй барилгын төсөвчнөөр зураг, төсөл гаргуулсан байна. Зураг төсөлтэй холбоотой ямар нэгэн маргаан зөрчил гараагүй байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн зураг төслийн дагуу гүйцэтгэхэд барилгын норм дүрэм зөрчигдсөн, үнийн хэлбэлзэл үүссэн зэргээр төсөвт өртөгт өөрчлөлт орсон асуудал гараагүй байна.

Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн байршилд өөрчлөлт ороогүй байна. Ашиглагч байгууллагын хүсэлтээр бүх төсөл арга хэмжээнүүдэд магадлашгүй ажлын зардлаар нэмж төсөв батлуулан хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэнд зохиогчийн зүгээс хийсэн хяналтын талаар ямар нэгэн акт, ажлын тэмдэглэл, баримт үйлдэгдээгүй байгаагаас үзэхэд зохиогчийн зүгээс зохих хяналт тавьж ажиллаагүй байна гэж үзэх үндэстэй байна.

## **Б.3. Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.**


Гүйцэтгэгч байгууллагуудын ажлын гүйцэтгэл, ажлын явцын хяналт хийсэн мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт, материалтай танилцаж үзэхэд тухайн жилд гүйцэтгэгч компаниудад ажиллах хүчин, техник хэрэгсэл, машин механизмийн хүрэлцээгүйгээс болж ажил саатсан тохиолдол гараагүй байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 9 төсөл арга хэмжээ захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ, батлагдсан зураг төсвийн дагуу хугацаандаа бүрэн хийгдсэн байна.

Аудитын явцад Өлгий сумдад 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг бэлтгэсэн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байдал болон ашиглалтыг газар дээр нь шалгаж үзэхэд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээтэй холбоотой маргаан гараагүй болно.



МХГазрын автомашин



Нэгдсэн эмнэлэгт суурилуулсан камерийн төхөөрөмж



Өлгий сумын 8-багийн 4 замын уулзварын гэрлэн дохио



Сансар эмнэлэгт нийлүүлсэн эмнэлгийн хэрэгсэлүүд



Аймгийн ЗДТГазарт нийлүүлсэн конторын тавилга



Аймгийн ЗДТГазарт нийлүүлсэн автомашин, тавилга, хэрэгсэл

Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжилтэнд захиалагчийг төлөөлж үе шатны ажлын гүйцэтгэлд ЗДТГазрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Барилга захиалагчийн албаны дарга, инженерүүд газар дээр нь хяналт тавьж, зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар тэмдэглэл хөтөлж баримтжуулсан байна.

#### **Б.4. Захиалагч байгууллага гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.**

Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд хийсэн гэрээний хэрэгжилтийг авч үзвэл 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн 10 төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжсэн байна.

Төсөл арга хэмжээний гэрээ тус бүр дээр Гэрээний ерөнхий нөхцөл, Захиалагчийн эрх үүрэг, Гүйцэтгэгчийн эрх үүрэг, Захиалагч, гүйцэтгэгчийн харилцан хүлээх үүрэг, Гэрээний нэмэлт нөхцөл, Гэрээний тусгай нөхцөлүүдийг тодорхой зааж өгчээ.

Тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэгч компаны гаргасан үе шатны ажлын гүйцэтгэлийг Барилга захиалагчийн албаны хяналтын инженерүүд газар дээр нь хяналт тавьж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Барилгын засварын ажил тус бүрт дундажаар 3-4 удаа газар дээр нь хяналт тавьж, шинээр барьж байгаа барилга байгууламжийн далд ажлын явцад байнгын хяналт тавьж, ажлын үе шатаар нь фотожуулж акт үйлдэн баримтжуулсан байна.

Аймгийн Төрийн сангаас ажлын гүйцэтгэл, “Хяналтын хүснэгт”, ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэл зэрэг зохих баримтуудыг үндэслэн урьдчилгаа болон эцсийн санхүүжилтийг тухай бүр саадгүйгээр олгож ирсэн байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.3-д заасны дагуу эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг тухайн орон нутгийн байгууллага сар бүр зохих маягтаар дараа сарын 03-ны дотор ТЭЗахирагчид хүргүүлэхээр заасан боловч зарим саруудын мэдээг хүргүүлээгүй байна.

Цаашид хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийн мэдээг сар бүр зохих маягтаар ТЭЗахирагчид хүргүүлж байх талаар зөвлөмж өгөв.

## Бүлэг 3

### Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил зохих үр өгөөжөө өгч байна.

#### **В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажил зохих үр өгөөжөө өгч байна.**

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин хангагдсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар Аймгийн Засаг даргын 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэхэд тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт үр дүнг хавсралт тайлан болгон оруулж, хөрөнгө оруулалтын ажлын зорилт, үр дүн хангагдсан гэж дүгнэжээ.

Ашиглагч байгууллагын зүгээс тавих дотоодын хяналтын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа сум орон нутгийн болон ашиглагч байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг төсөл тус бүр дээр байгуулж ашиглагчийн хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна.

Хэрэглэгч буюу ашиглагч байгууллагыг төлөөлж, захиалагч байгууллагууд гэрээ хийж байгаа ба гэрээндээ ашиглагч байгууллагын зүгээс тавих хяналтыг тодорхой тусгаагүй боловч ТАХ-г ашиглалтанд хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ашиглагч байгууллагын төлөөлөл зайлшгүй орж, актанд гарын үсэг зурж ирсэн байна.

Аудитын явцад 2017 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн талаар ашиглагч байгууллагуудаас санал авахад төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой гомдол гараагүй болно.

В.2. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналт зохих түвшиндээ байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.4-д заасны дагуу захиалагчийн санхүүжилт хүссэн материалыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн хянан баталгаажуулсаны дараа албан тоот, “Хяналтын хүснэгт”-ийг бөглүүлж холбогдох материалын хамт Хөрөнгө оруулалтын мэргэжилтнээр хянуулсаны дараа ажлын санхүүжилтийг олгож ирсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудын хувьд хөрөнгө оруулалтын мэргэжилтэний бөглөсөн “Хяналтын хүснэгт”, хянагдсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн ажлын санхүүжилтийг гүйцэтгэгчид урьдчилгаа санхүүжилт, эцсийн санхүүжилтээр олгосон байна.

Ажлын явцын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр, эцсийн санхүүжилтийг ТАХ-г ашиглалтанд хүлээж авсан акт гарсаны дараа олгосон байна. Зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг холбогдох материалыг үндэслэн шилжүүлжээ.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудад ТЕЗ-дын зүгээс тавих дотоод хяналтыг аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс хэрэгжүүлж, ТАХ-ний явц болон гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг олгоход журамд зааснаар ажлын гүйцэтгэлийг үндэслэн “Хяналтын хүснэгт”-ийг бөглөх, хэрэгжсэн ТАХ-г хүлээж авах зэрэг ажлын бүх үе шатанд хяналт тавьж ажиллаж байна.

*В.3. Төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр орон нутгийн нийгэм, эдийн засагт тодорхой үр өгөөж гарч байна.*

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тус бүрээр үр өгөөжийг төлөвлөж тооцоогүй боловч тайлант онд төлөвлөсөн бүх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Үүнээс үзэхэд төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр орон нутгийн нийгэм, эдийн засагт тодорхой үр өгөөж гарч байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжэний ихэнх нь зам, дэд бүтцийг сайжруулах, эмнэлгийн байгууллагын тоног төхөөрөмж бэлтгэх арга хэмжээнүүд байна. Дээрхи байдлаас үзэхэд хөрөнгө оруулалтын арга хэмжээг аль болох үр өгөөж хүртэгчийн тоо их үр өгөөжтэй арга хэмжээнд төлөвлөж ирсэн байна.

Харин 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Өлгий сумд хэрэгжиж эхэлсэн 37,7 хувийн гүйцэтгэлтэй “Асрамжийн газрын байр барих” төсөл арга хэмжээнд 2017 онд хөрөнгө төлөвлөөгүй, ажил хийгдээгүй байна.

Нэгэнт эхэлсэн хөрөнгө оруулалтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бодлого баримтлаагүйгээс урьд хийгдсэн хөрөнгө оруулалтын үр ашиг буурч, барилгын ажлын үнэ өртөгт сөрөг нөлөө үзүүлэх үр дагавартай байна. Цаашид хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд санхүүгийн нөөцийг зөв хуваарилж, тасралтгүй байдлыг хангаж ажиллах нь зүйтэй байна.

2017 онд хэрэгжсэн засварын ажлуудын төсөвт өртгийг тусгай эрх бүхий барилгын мэргэшсэн төсөвчний баталгаа өгч гаргасан зураг төсвийн дагуу тогтоож байгаа учир ажлын төсөвт өртгийг нэмэгдүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөнд орон нутагт шаардлагатай ажлуудыг төлөвлөсөн байна.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд Төсвийн тухай хуулийн холбогдох заалт болон “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын заалтууд зөрчигджээ.
3. Зарим тендерийн цахим сайтад байршуулсан урилга байршуулах, нээх мэдээлэлийн хугацаа зөрүүтэй, үнэлгээний хорооны тайлангийн бичиг баримтын бүрдүүлэлтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.
4. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.
5. Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн хэрэгжсэн байна.



## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

### **1.Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:**

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээг тусад нь, хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинжтэй ажлуудыг тусад нь ялгаж төлөвлөж, баталж байх.

### **2.Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга А.Даримхан танаа:**

1.Үнэлгээний хорооны бичиг баримтын бүрдүүлэлтийг зохих журмын дагуу бүрэн бүрдүүлж, цахим сайтад тавьсан мэдээлэлийн үнэн зөв байдалд тогтмол хяналт тавьж ажиллах.

**Холбогдох байгууллагын санал**

**Холбогдох байгууллагын санал**

**ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

**ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

**ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

К.РИЗА

АУДИТОР

Р.БАЯРМАА